**МОНГОЛ УЛС**
**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 13 өдөр Дугаар А/91 Хэрлэн сум

Зөвлөгөө, мэдээлэл өгөх
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхдийн мөнгийг өрхийн амьжиргааны түвшинтэй уялдуулан олгох болсонтой холбогдуулан иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

| | |
|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга |
| Нарийн бичиг: | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн |
| Гишүүд | Аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн |
| | Авто тээврийн төвийн дарга |
| | Улсын бүртгэлийн хэлтсийн дарга |
| | Нийгмийн даатгалын хэлтсийн дарга |
| | Татварын хэлтсийн дарга |

2.Харьяалах нутаг дэвсгэртээ ажлын хэсэг байгуулж, дээрх чиглэлээр иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгөхийг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3.Иргэдэд хүүхдийн мөнгийг олгохтой холбоотой зөвлөгөө, мэдээллийг өгөх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг удирдлага арга зүйгээр хангаж, ажиллахыг Ажлын хэсгийн ахлагчид үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ц.ЧОГСОМЖАВ

D:\My Document Захирамж 2023

23101026О